Сарын урьдчилсан төлөв

2026 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- **Баруун** (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- **Төв** (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул)
- **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- **Говь** (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "бүх нутгаар" гэсэн нэр томьёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0˚-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон “Хиймэл оюун ухаан, тоон загварчлал, судалгааны хэлтэс"-ээс тодруулах боломжтой.


Уур амьсгалын тойм

Арваннэгдүгээр сарын агаарын температурын ОЖД нь Алтай, Хангай, Хэнтийн уулархаг нутгаар -12…-18°C, Хөвсгөлийн уулархаг нутгаар -18...-22°C, Алтайн өвөр говь болон говийн бүс нутаг, Дорнодын тал газраар -2...-8°C, бусад нутгаар -8...-12°C хүйтэн байдаг (***Зураг 1***).


90°E
95°E
100°E
105°E
110°E
115°E
120°E
52°N
50°N
48°N
46°N
44°N
42°N
40°N
-20
-18
-16
-14
-12
-10
-8
-6
-4
-2


Зураг 1. 11–р сарын агаарын температурын ОЖД, [°C].

Арваннэгдүгээр сарын агаарын дундаж температур 1979, 1981, 1984–1987, 1989, 1993, 1996, 2000, 2002–2003, 2009, 2011–2012, 2015–2016, 2023 онуудад ОЖД–аас 1–5°C–аар хүйтэн байсан бол 1980, 1983, 1988, 1994–1995, 1998–1999, 2001, 2005–2008, 2010, 2013–2014, 2020–2021, 2022, 2024, 2025 онуудад ОЖД-аас 1–3°C–аар дулаан байсан байна. Харин 2000 оны 11–р сард ОЖД–аас 4.8°C–аар хүйтэн байсан нь 1979 оноос хойш тохиолдсон хамгийн хүйтэн, 1994 оны 11–р сард ОЖД–аас 3.4°C–аар дулаан буюу түүхэн дэх хамгийн дулаан сар болж өнгөрсөн байна (***Зураг 2***).




Зураг 2. 11–р сарын температурын олон жилийн явц
[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 4–8 мм, Алтайн өвөр говь болон говийн аймгуудын нутгаар 0–2 мм, бусад нутгаар 2–4 мм цас ордог байна **(*Зураг 3***).


90°E
95°E
100°E
105°E
110°E
115°E
120°E
52°N
50°N
48°N
46°N
44°N
42°N
40°N
2
4
6
8
10

Зураг 3. 11–р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм]

Арваннэгкүгээр сарын нийлбэр хур тунадас 1979, 1987, 1990, 1992, 1996, 2000, 2003, 2009–2012, 2015–2016, 2023, 2025 онуудад олон жилийн дунджаас ахиу, 1985, 1988–1989, 1995, 1997, 1999, 2004–2008, 2014, 2018, 2021, 2022, 2024 онуудад ОЖД–аас харьцангуй бага хур тунадас оржээ. 2008 онд нийт нутгийн дунджаар ОЖД–аас 2.5 мм–ээр бага тунадас орсон нь түүхэн дэх хамгийн хуурай 11–р сар болсон бол 2023 онд ОЖД–аас 5.5 мм–ээр ахиу тунадас орсон нь 1979 оноос хойшхи хамгийн их тунадастай 9–р сар болсон байна **(*Зураг 4*)**.



Зураг 4. 11–р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц
[Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Баруун аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Баян–Өлгийн нутаг, Ховдын ихэнх, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас хүйтэн **(*Зураг 5*)**, хур тунадас Говь–Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна **(*Зураг 6*)**.

Агаарын температур, хур тунадасны хоногийн явцыг **(*Зураг 7*)**–д харуулав. Агаарын температур нэгдүгээр арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх бол нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүл, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үеэр ихэнх нутгаар цас орж, салхи ширүүсэн, цасан болон шороон шуурга шуурч болзошгүй байна.

Төвийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас хүйтэн **(*Зураг 5*)**, хур тунадас нийт нутгаар ОЖД–ийн орчим байна**(*Зураг 6*)**.

Агаарын температур, хур тунадасны хоногийн явцыг **(*Зураг 8*)**–д харуулав. Агаарын температур нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүл, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх бол нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлээр ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаанд, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар цас орж, салхи ширүүсэн цасан шуурга шуурч болзошгүй байна.

Зүүн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Хэнтийн нутаг, Дорнодын хойд хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад нутгаар дунджийн орчим **(*Зураг 5*)**, хур тунадас Сүхбаатарын өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна **(*Зураг 6*)**.


Агаарын температур, хур тунадасны хоногийн явцыг (***Зураг 9***)–д харуулав. Агаарын температур нэгдүгээр арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх бол нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар цас орж, зарим газраар цасан шуурга шуурч болзошгүй байна.


Говийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Өмнөговийн ихэнх нутгаар ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунжийн орчим **(*Зураг 5*)**, хур тунадас Өмнөговийн баруун хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна **(*Зураг 6*)**.

Агаарын температур, хур тунадасны хоногийн явцыг **(*Зураг 10*)**–д харуулав. Агаарын температур нэгдүгээр арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ОЖД–аас хүйтэн байх бол нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна.


Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд, хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар цас орж, зарим газраар цасан шуурга шуурч болзошгүй байна.


90°E
95°E
100°E
105°E
110°E
115°E
120°E
52°N
50°N
48°N
46°N
44°N
42°N
40°N
X
H
-20
-18
-16
-14
-12
-10
-8
-6
-4
-2


Зураг 5. 2026 оны 11–р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, C^0
[Н–агаарын температур ОЖД–ийн орчим, Х–агаарын температур ОЖД-аас хүйтэн]


90°E
95°E
100°E
105°E
110°E
115°E
120°E
52°N
50°N
48°N
46°N
44°N
42°N
40°N
Н
И
2
4
6
8
10

Зураг 6. 2026 оны 11–р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм
[Н–хур тунадас ОЖД–ийн орчим, И–хур тунадас ОЖД–аас ахиу]




Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2026 оны 11–р сарын агаарын температур, хур тунадасны явц
[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]




Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2026 оны 11–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2026 оны 11–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2026 оны 11–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]

ЗӨВЛӨМЖ

Энэ сард агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджаас хүйтэн, хур тунадас нутгийн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас ахиу байх төлөвтэй байна.

Арваннэгдүгээр сарын эхэн болон хоёрдугаар арван хоногт харьцангуй дулаан өдрүүд үргэлжлэх боловч агаарын температур огцом буурах, цочир хүйтрэх зэрэг үзэгдэл ажиглагдах магадлалтай байна. Гол хүйтрэлт нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүл, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд ажиглагдах төлөвтэй байна.

Иймд малчид хадлан тэжээл бэлтгэх, малын хашаа хороо болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд тухайн үеийн богино хугацааны цаг агаарын нарийвчилсан урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлгийг тогтмол авч ашиглахыг зөвлөж байна.